

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГА, СТРАТЕГИ

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСТОЙ ТЭМЦЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Г.Хосбаяр

ДХИС-ийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага,
стратегийн тэнхимийн дэд профессор, докторант, хошууч

Товч агуулга: Өгүүлэлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис бэлдмэлтэй тэмцэж буй олон улсын болон бус нутгийн үйл ажиллагаа, эрх зүйн бодлогын орчин, стратеги, цаашидын чиг хандлага мөн цаашид анхаарах асуудлын талаар судлаачийн үзэл бодлыг илэрхийлсэн.

Түлхүүр үгс: Хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бодис бэлдмэл, эрх зүйн орчин, хорих байгууллага, хоригдол, анхаарах асуудал.

Abstract: This article examines the researcher's perspective on international and domestic approaches, the legal and policy framework, intervention strategies, anticipated future developments, and critical issues demanding consideration in the ongoing struggle against narcotic drugs and psychoactive substances.

Keywords: Narcotics, psychotropic substances, legal environment, imprisonment, prisons, detainees, issues of concern.

Оршил

Хүн төрөлхтөн үүссэн цагаас эхлэн үнэнийг эрэлхийлэгч байсаар ирсэн нь тэдний жам ёсны эрхтэй холбоотой бөгөөд энэхүү эрхийг бодитой хангах арга замыг олох зорилго агуулсан мэдлэгийн салбарууд төрөн гарч, эдгээрийн нэгдэл, ялгарал явагдсаны үр дүнд бие даасан салбар шинжлэх ухаан хөгжиж, дэлхийн нийтийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж байгаа билээ.

Даяаршил, шинжлэх ухаан, технологийн хөгжлийг дагаж улс орны аюулгүй байдал, хил хязгаарын уламжлалт ойлголт үндсэндээ өөрчлөгдөж байгаа бөгөөд энэ хандлага өдгөө нэгэнт эхэлсэн аж

үйлдвэрийн IV хувьсгалын нөлөөгөөр улам гүнзгийрэх нь тодорхой болсон. Дэлхий ертөнц нэг бүхэл систем болохын хувьд бүх улс хамтдаа, тогтвортой хөгжих ёстой гэсэн зорилтыг хөгжингүй улс орнууд дэвшүүлэх болсон нь үүнтэй холбоотой.

Дэлхий нэгдмэл бүхэл. Түүний хэсгүүд өөр хоорондоо салшгүй холбогдсон. Байгальд ч, нийгмийн амьдралд ч огт тусгаарлагдсан үзэгдэлүүд ба зүйлс байхгүй. Бодит байдалд үзэгдэл болон үйл явц, тэдгээрийн бүх талуудын харилцан ажиллагаа, нийтлэг харилцан холбоос байгаа нь чухамхүү энэ зарчмаар нөхцөлдөнө¹.

¹ О.Үржин. “Эрсдлийн үнэлгээ, системийн хандлага тогтвортой хөгжлийн тулгуур үндэс

болох нь”. Эрсдэлд суурилсан тогтвортой хөгжил сэдэвт Олон улсын эрдэм

Аливаа асуудлыг шийдвэрлэхэд юуны өмнө шинжлэх ухааны үндэслэлтэй, гүнзгий судалсан ойлголтын суурь, мөн томъёолол, ойлголтод үндэслэсэн аюулгүй байдал, эрх зүйн орчин, хөгжлийн чиг хандлага чухал үүрэгтэй.

Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно”¹ гэж заасан нь төрийн үйл ажиллагааны бүх системд хамаатай юм.

Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хүрээнд эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад үзэл баримтлалын шинжтэй томоохон өөрчлөлт орсон.

2017 онд шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар нийгмийн үнэт зүйл, хуулиар хамгаалагдсан нийгмийн ашиг сонирхлыг зөрчсөн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, ялангуяа эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хоригдлыг ангилан хуваарилах, хорих ялыг

ялгамжтай эдлүүлэхэд зарчмын шинжтэй өөрчлөлтүүд орсон. Энэхүү өөрчлөлттэй холбоотойгоор тодорхой бэрхшээлүүд тохиолдож байгааг онолын цэгцтэй мэдлэг төлөвшөөгүй, мөн эрх зүйн орчинтой холбон тайлбарлаж болох юм.

Нэг. Олон улсын эрх зүйн орчин

Нийгэм, улс төрийн хурцадмал байдал нэмэгдэж байгаа өнөө үед макро эдийн засгийн орчин үндсээрээ өөрчлөгдсөн. Хөгжингүй болон хөгжиж буй бүс нутагт эдийн засгийг либералчлах бодлого нэмэгдэж, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт нэмэгдэж, үндэстэн дамнасан корпорациудын бараа таваар, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээг улс орон эсвэл бүс нутаг, газарзүйн хувьд давуу талуудад хамгийн ашигтай санхүүгийн үйл ажиллагаа явуулах болжээ.

Ялангуяа Латин Америк, Африк, Азийн хөгжиж буй улс орнуудад олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт нэмэгдэж, эдийн засгийн хувьд өсөлт үзүүлсэн хэдий ч улс төрийн тогтворгүй байдал, үндэстэн хоорондын мөргөлдөөн, байгалийн гамшиг, эдийн засгийн буруу менежментийн үр дагавраас үүдсэн сөрөг өөрчлөлтүүд даамжирч баялагийн тэгш бус хуваарилалт, санхүүгийн дарамт, төрийн үйлчилгээнд хатуу хязгаарлалт тогтоосноос хүн амын эмзэг хэсэг улам нэмэгдэж гэмт хэрэг, зөрчил гарах, түүнчлэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус үйлдвэрлэл, наймаанаас олсон

шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ хот, 2023 он. 14 дэх тал.

¹ “Алсын хараа 2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого батлах

тухай Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2020. №25.

орлогын уруу таталтад илүү өртөмтгий болсон¹.

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар хэрэглэхийн сөрөг үр дагавар нь ялангуяа ядуу буурай болон хөгжиж буй орнуудад илүү хүндээр тусдаг. Эдгээр улс орнууд ихэвчлэн урьдчилан сэргийлэх, донтсон этгээдийг эмчлэх, нөхөн сэргээх үйлчилгээнд зарцуулах эдийн засгийн нөөц багатай, ялангуяа эмчилгээ хийгээгүй тохиолдолд хувь хүний өвчлөл, нас баралтын эрсдлийг нэмэгдүүлж, хувь хүн, гэр бүл, нийгэм, боловсрол, ажил мэргэжлийн болон бусад үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг.

Иймд дэлхийн эдийн засаг, олон улсын худалдаа өргөжин тэлэхийн хэрээр мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түгээлт илүү өргөн хүрээг хамарч, улмаар эдгээр бүтээгдэхүүнийг улс орнуудын засгийн газраас хянах, зохицуулахад хүргэсэн.

Олон улсын хүрээнд мансууруулах бодист хяналт тавих стратегийн бодлого нь эртний түүхтэй бөгөөд мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, хяналт тавих системийг бүрдүүлэх хүчин чармайлт 1909 онд Шанхай хотноо Опиумын Комисс хуралдсанаар олон улсын гэрээ байгуулах эхлэл тавигдсан гэж судлаачид үздэг.

1909 онд дэлхийн түүхэнд анх удаа 13 орон оролцсон, хар тамхины олон улсын комиссын зөвлөлгөөн болсон бөгөөд 1912 онд Гаага хотноо зохиогдсон хар тамхины талаарх олон улсын бага хурлаас эмийн зүйлд хяналт тавих тухай олон улсын гэрээ зурагдсан болно²

Олон улсын түвшинд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын үйлдвэрлэл, түгээлтийг хянахтай холбоотой олон улсын конвенцууд хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнд:

-Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1972 оны Протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулсан “Мансууруулах эмийн тухай”³ 1961 оны конвенц;

- НҮБ-ын 1971 оны “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай”⁴ конвенц;

- НҮБ-ын 1988 оны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц”⁵ зэрэг болно.

Монгол Улс ирээдүйд үүсэж болох эрсдэлт нөхцөл байдлыг харгалзан үзэж, энэ чиглэлээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө тодорхой үүрэг, хариуцлага хүлээж байгаагийн илрэл болгож 1990 онд НҮБ-ын “Мансууруулах эмийн тухай 1961 оны конвенци”, 1999 онд “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай 1971 оны конвенци”, 2001 онд “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг 1988 оны конвенци”,

¹ The Social Impact of Drug Abuse. United Nations Office on Drugs and Crime. 1995. Page 3.

² The United Nations and Drug Abuse control. 2 N, UN, 1989, p.63-64

³ Монгол Улсын 1990 оны 12 дугаар сарын 06-ны өдөр нэгдэн орсон. Тус конвенцид 130 нэр төрлийн мансууруулах бодис багтсан.

⁴ Монгол Улс 1999 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр нэгдэн орсон. Тус конвенцид 110 нэр төрлийн сэтгэцэд нөлөөт бодис багтсан.

⁵ Монгол Улс 2001 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр нэгдэн орсон. Тус конвенцид 21 нэр төрлийн нэршилтэй мансууруулах бодис багтсан.

2008 онд “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг 2000 оны конвенци” зэрэгт тус тус нэгдэн орсон.

НҮБ-ын “Мансууруулах эмийн тухай 1961 оны конвенцийн нэгдүгээр зүйлд мансууруулах бодис болон түүний эргэлтийг хууль ёсны болон хууль бус гэж ангилах үндэслэлийг, хоёрдугаар зүйлд хяналтад хамаарах бодисыг тодорхойлохдоо “бүх төрлийн мансууруулах бодис нь хяналтад байна” гэж заасан бөгөөд нэгдэн орсон талууд мансууруулах үйлчилгээтэй байж болзошгүй гэж үзсэн бодис, эм бэлдмэлийн талаарх мэдээллийг холбогдох олон улсын байгууллагад нэн даруй хүргэх үүрэгтэй.

Мөн зүйлийн тав дахь хэсэгт “гэрээнд нэгдэн орсон талууд нь тухайн орны хүн амын эрүүл мэнд, ахуй амьдралыг хамгаалах зайлшгүй шаардлагатай тохиолдолд эмнэлгийн болон эрдэм шинжилгээ, судалгаанд ашиглахаас бусад зорилгоор мансууруулах бодисыг худалдаалахыг хориглохоор” заажээ.

Уг конвенциор үйлдвэрлэх, бэлтгэх, худалдаалах, импортлох, экспортлох, хуваарилах болон ашиглах явдлыг хязгаарлаж, хууль бус эргэлтийн аливаа хэлбэрийг хориглосон бөгөөд конвенцид заасан журмын дагуу мансууруулах бодисын олон улсын худалдаа нь мансууруулах бодист хяналт тавих олон улсын хорооны хяналтад байхаар тусгасан.

НҮБ-ын “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” конвенцийг Вена хотноо 1971 оны 2 дугаар сарын 21-

ний өдөр 71 орны төлөөлөгчид оролцон баталж, 1976 оны 8 дугаар сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд мансууруулах бодис болон түүний хууль бус эргэлтийн тухай ойлголтыг тусгагдсан нь мансууруулах бодисын борлуулалтыг хууль ёсны ба хууль бус гэдгийг зааглах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Конвенцийн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Оролцогч тал нь тухайн орны хүн амын эрүүл мэнд, ахуй амьдралыг хамгаалах илүү тохиромжтой арга гэж үзвэл эмнэлгийн болон эрдэм шинжилгээ судалгааны ажилд шаардлагатайгаас бусад тохиолдолд түүнийг худалдаалахыг хориглох” тухай тусгаснаас гадна хяналтад хамаарах бодисыг тодорхойлохдоо “бүх төрлийн мансууруулах бодис нь хяналт дор байна” гэж заасан.

Дээрх конвенциор мансууруулах бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх, худалдаалах, импортлох, экспортлох, хуваарилах болон ашиглах явдлыг хязгаарлан, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн аливаа хэлбэрт хориг тавьсан юм. Энэ нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах явдалд тавих эрүүгийн эрх зүйн хоригийн үндэс болсон юм.

2001 онд Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын 1988 оны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц”-ийн нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус

¹ НҮБ-ын 1988 оны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц”, “Төрийн

мэдээлэл” тусгай дугаар - 4 дүгээр боть, УБ., 2006. 1035 дахь тал

эргэлттэй тэмцэх чиглэлээр талуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэхэд байнга хэрэглэгддэг угтвар бодис, түүхий эд, урвалуудын жагсаалтыг гаргаж тэдгээрийг хяналтад авах асуудлын олон улсын эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд чиглэсэн.

Энэхүү конвенциор мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт, түүнээс олох ашиг орлогыг олон улсын хяналтад авах, хууль бус эргэлттэй тэмцэх, хууль бус эргэлтээс олсон ашиг орлого, эд хөрөнгийг хураан авах, энэ төрлийн үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг бүрдүүлэх, гэмт хэргийг шалгах явцад талууд эрх бүхий байгууллагуудаараа дамжуулан бие биедээ эрх зүйн туслалцаа үзүүлэх зэрэг боломжийг бүрдүүлж өгчээ. Тухайлбал, мансууруулах сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг шалгах явцад талууд бие биедээ эрх зүйн туслалцаа үзүүлэх бөгөөд уг туслалцаа нь нотлох баримт цуглуулах, байцаах, нэгжих болон баривчлах ажиллагаа явуулах, тодорхой эд зүйл, газарт үзлэг хийх, мэдээлэл олж авах зэрэгтэй холбоотой байхаар зохицуулсан.

Хоёр. Үндэсний эрх зүйн зохицуулалтын орчинд хийсэн шинжилгээ

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин

төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”¹, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө”² гэж хуульчилсан.

Манай улсын төрөөс мансууруулах бодисын талаарх олон улсын санал, санаачилга болон үүрэг, зорилтыг хангахын төлөө хүчин чармайлт гаргаж ирсэн бөгөөд 2002 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг баталж, 2002 онд баталсан Эрүүгийн хуульд дээрх төрлийн гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг бий болгож, 2000-2005 онд “Хар тамхи, мансуурахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”, 2017 оноос “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажилласан.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын³ 3.4.4.1-д “Иргэдийн терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүчирхийллээс хамгаалагдах нөхцөлийг сайжруулна” гэж, 3.4.4.3-т “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлнэ” гэж, 3.4.4.4-т “Нийгэмд эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

¹ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ., 1992. №1

² Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2002. №46.

³ “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” / <https://www.legalinfo.mn/law/details/6163>

талаархи сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ” гэж, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн ¹ 4.3.4-т “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 2.2 дахь зорилтод “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.” гэж; 2.7 дахь зорилтод “Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.” гэж заасан бөгөөд зорилтыг хэрэгжүүлэхэд дараах үр дүнд хүрэхээр “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.”; “Үндэстэн дамнасан зохион

байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ” ² гэж төлөвлөсөн.

Мөн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх судалгаа, мэдээлэл, сургалт сурталчилгааны салбар хоорондын хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлнэ.”; “Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг нийгмийн байгууллага, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.”; “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай (эдийн засгийн, цахим гэмт хэрэг болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах гэх мэт) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, олон улсын хамтын ажиллагааг тогтмолжуулна.”; “Тэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлж, мансууруулах бодис хэрэглэгч, донтогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх төвийг

¹ “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” / <https://www.legalinfo.mn/annex/?lawid=12120>

² “Алсын хараа 2050” Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого батлах

тухай Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2020. №25.

бий болгон олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлыг цогц байдлаар хэрэгжүүлнэ.”; Тусгай чиг үүрэг бүхий байгууллагууд болон хилийн боомтыг хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлийг илрүүлэх орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, түүхий эд (перкурсор)-д хяналт тавих чиг үүрэг бүхий бүтэц, нохойн сургалтын төв байгуулж, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.”; “Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлийн судалгааг олон улсын түвшинд хэрэглэдэг стандартын дагуу хийж эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөтгөж, судалгаа хийх байгууллагад тавигдах шаардлагыг тодорхой болгож, чадавхжуулна”¹ гэж тус тус заасан нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хяналтыг нэмэгдүүлэх тухай төрөөс баримтлах бодлого, стратегийг тодорхойлсон.

Монгол Улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль”-ийг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дээрх хуулийг дагаж гарсан дараах эрх зүйн актууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:

-Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 196 дугаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолоор “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр Буянт-Ухаа, Сүхбаатар, Алтанбулаг, Замын-Үүд дэх хилийн боомт, Улаанбаатар хот дахь гаалийн газраар нэвтрүүлж байх”, “Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт”, “Эдгээр бодисыг ашиглах байгууллагын жагсаалт”, “Ашиглах журам”, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эд болон бэлтгэх зориулалтын тоног төхөөрөмжийг хадгалах, устгах журам”;

-Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 247 дугаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны ажиллах журам”;

-Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 350 дугаар “Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тогтоолын 9 дүгээр хавсралтаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны бүрэлдэхүүн”;

-Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/81 дүгээр тушаалаар “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр

¹ Мөн тэнд.

нэвтрүүлэхэд тавих хяналтын тусгай журам”-ыг тус тус баталжээ.

Монгол Улсын “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”¹ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой дараах харилцааг зохицуулсан. Үүнд:

Хуулийн нэр томъёоны тодорхойлолтод зааснаар “мансууруулах эм” гэж донтуулах нөлөөлөл үзүүлдэг, “Мансууруулах эмийн тухай” 1961 оны Нэгдсэн конвенцийн жагсаалтад орсон эм бэлдмэлийг, “сэтгэцэд нөлөөлөх эм” гэж сэтгэцэд хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” 1971 оны конвенцийн жагсаалтад орсон бодисыг ойлгоно гэж хуульчилсан.

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас

хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг Монгол Улсын Эрүүгийн хууль² -д дараах байдлаар хуульчилсан.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.7-д заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах”, 20.8-д заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах”, 20.9-д заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших”, 20.10-д заасан “Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах” зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож, дээрх үйлдэлд эрх хасах, зорчих эрх хязгаарлах, торгох, хорих ял оногдуулахаар заасан.

Хүснэгт 1. Олон нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг

ЭХ-ийн 20 дугаар бүлэг: Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг					
1	“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	Эрх хасах	1-5 жил зорчих эрх хязгаарлах	40.000-200.000 нэгжээр торгох	1-20 жил эсхүл бүх насаар хорих ял
2	“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах”	-	1-5 жил зорчих эрх хязгаарлах	5400-27.000 нэгжээр торгох	1-12 жил хорих ял
3	“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших”	2-5 жил эрх хасах	1-5 жил зорчих эрх хязгаарлах	5400-27.000 нэгжээр торгох	1-5 жил хорих ял
4	“Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах”	Эрх хасах	1-5 жил зорчих эрх хязгаарлах	40.000-200.000 нэгжээр торгох	1-12 жил хорих ял

¹ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2010. №25.

² Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб., 2016. №07

**Монгол Улсын Зөрчлийн тухай
хууль¹-н ар Мансууруулах эм, сэтгэцэд
нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих**

**тухай хууль зөрчихөд оногдуулах
шийтгэлийг хуульчилсан байдал**

Хүснэгт 2.

№	Зөрчлийн тухай хуулийн зүйл, заалт	Хуулийн санкц
1	6.4 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих	1.Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөлтэй мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг: 1.1.эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, экспортлогч, импортлогч талууд байгуулсан гэрээнд заасан нэр төрөл, тоо, хэмжээнээс хэтрүүлсэн; 1.2.эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагад зохих зөвшөөрөлгүйгээр олгосон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 2.Мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт эм, бодис, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг: 2.1.үйлдвэрлэх; 2.2.бэлтгэх; 2.3.боловсруулах; 2.4.хадгалах; 2.5.бүртгэх; 2.6.хуваарилах; 2.7.тээвэрлэх; 2.8.улсын хилээр нэвтрүүлэх; 2.9.устгах журам зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 3.Мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт эм, бодисыг: 3.1.зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн худалдаалсан; 3.2.зохих зөвшөөрөлгүйгээр худалдаалсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2	6.20 дугаар зүйл. Хүүхдийн эрхийг зөрчих	7.Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архидаан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3	9.4 дүгээр зүйл.Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль зөрчих	3.Дээд боловсролын сургалтын байгууллагын: 3.3.үйл ажиллагаанд согтууруулах ундаа, мансууруулах бодис, хүн, байгаль орчинд халтай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг байгууллага, аж ахуйн нэгжээс хандив, тусламж авсан, тэдний үйл ажиллагааг сурталчилсан, дэмжсэн, хувьцааг нь
4	10.13 дугаар зүйл.Ажиллах хүч	5.Хуульд заасныг зөрчиж:

¹ Зөрчлийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №24

	гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль зөрчих	5.2.химийн хортой, тэсрэх, эсхүл цацраг, биологийн идэвхт бодистой харьцах, хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх, борлуулах зэрэг олон улсын хэмжээнд хориглосон ажилд зуучилсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5	14.6 дугаар зүйл.Автотээврийн тухай хууль зөрчих	6.Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн жолоочийг замд гарах зөвшөөрөл олгосон бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6	14.7 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	3.Жолооч: 3.1.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон; 3.2.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 4.Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 5.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна. 5.5.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон, эсхүл согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн этгээдээр тээврийн хэрэгсэл жолоодохыг шаардсан, эсхүл нөлөөлсөн бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7	14.11 дүгээр зүйл.Усан замын тээврийн тухай хууль зөрчих	4.Усан замын тээврийн хэрэгслийн ахмад, багийн гишүүд, өмчлөгч, эзэмшигч, жолооч нь согтууруулах ундаа, мансууруулах үйлчилгээтэй эм, бодис хэрэглэсэн үедээ усан замын тээврийн хэрэгсэл жолоодсон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жил хүртэл хугацаагаар хасаж хүнийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх талаар олон улсын хамтын ажиллагааны талаар дараах хэлэлцээр, санамж бичиг байгуулжээ. Үүнд:

-2001 онд Монгол Улсын ХЗДХЯ болон ОХУ-ын Дотоод хэргийн яамны хил орчмын бүс нутгийн дотоод хэргийн албадын хамтын ажиллагааны хэлэлцээр;

-2005 онд Монгол Улсын ХЗДХЯ, ОХУ-ын мансууруулах

бодисын эргэлтэд хяналт тавих Холбооны албаны хооронд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон тэдгээрийн түүхий эдийн хууль бус эргэлттэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр;

-2006 онд Монгол Улсын болон ОХУ-ын мансууруулах бодисын эргэлтэд хяналт тавих Холбооны алба хоорондын хил орчмын хамтын ажиллагааны зохион байгуулалтын тухай протокол;

-2010 онд Монгол Улсын ХЗДХЯ болон ОХУ-ын мансууруулах бодисын эргэлтэд хяналт тавих Холбооны алба хоорондын хил орчмын хамтын ажиллагааны зохион байгуулалтын тухай протокол;

-2011 онд Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд «Гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтран ажиллах тухай» хэлэлцээр;

-2011 онд Монгол Улсын ХЗДХЯ, БНХАУ-ын НАХЯ-ны Хар тамхитай тэмцэх газрын хооронд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийн хууль бус эргэлттэй тэмцэх талаар хамтран ажиллах санамж бичгийг тус тус байгуулсан.

Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх үйл ажиллагааны эрх зүйн орчинд хийсэн дүн шинжилгээгээр тухайн төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын

болон үндэсний хууль тогтоомж бүрдсэн гэж үзэхээр байна.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтын 3.5-д “Мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх, түүний дотор хар тамхи хэтрүүлэх хэрэглэх, архийг эрүүл мэндэд хортойгоор хэрэглэх явдлаас урьдчилан сэргийлэх, эмчлэх үйл ажиллагааг сайжруулах” талаар засгийн газруудын амлалтыг тусгасан. Бусад хэд хэдэн зорилтууд нь эмийн бодлоготой холбоотой эрүүл мэндийн асуудалд онцгой хамааралтай, ялангуяа ДОХ-ын тархалтыг зогсоох, вируст гепатиттай тэмцэх тухай зорилт 3.3; зорилт 3.4, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих; зорилтот 3.8, бүх нийтийг эрүүл мэндийн хамруулах тухай; болон зорилтот 3.b-ийг хямд үнээр зайлшгүй шаардлагатай эмэнд хүртээмжтэй болгох тухай дурьдсан¹.

Монгол Улсын Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 68 дугаар тушаалаар батлагдсан “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, хангах нийлүүлэх” тухай журам², мөн сайдын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/184 дүгээр “Журамд өөрчлөлт оруулах тухай”³ тушаалаар Монгол Улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтыг шинэчлэн баталж, мансууруулах үйлчилгээтэй 14

¹ <https://www.undp.org/sustainable-development-goals/good-health>

² Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар “Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, хангах нийлүүлэх журам”
// <https://legalinfo.mn/mn/detail/11090>

³ Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/184 дүгээр “Журам шинэчлэн батлах тухай тушаал”

<https://moh.gov.mn/uploads/files/24f44a6f8321fc6c39f8534624bbb.pdf>

төрлийн, сэтгэцэд нөлөөт үйлчилгээтэй 32 төрлийн эм, эмийн түүхий эд агуулсан бодисыг хамааруулсан байдаг.

Монгол Улсын талаар НҮБ-ын шинжээчдийн хийсэн үнэлгээнд героин, амфетамин, каннабис, экстазийн төрлийн мансууруулах бодисын хэрэглээ өсөлттэй, тархацын хувьд каннабис хамгийн их, намуугийн тархалттай, экстазийн урсгал БНХАУ-аас чиглэсэн, героин, амфетамины төрлийн бодисын худалдааны замууд дайран өнгөрч байна гэж үзсэн бөгөөд тус байгууллагын 2016 оны тайланд дурьдсанаар Монгол Улс нь хар тамхи, мансууруулах бодис “Дамжин өнгөрөгч улс” гэж үзэж байсан бол НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-ын тайланд дурьдсанаар манай орныг “Хэрэглэгч улс” орон болсон гэж дүгнэсэн байна¹.

Илтгэлийн зорилготой уялдуулан эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн холбогдох зарчим, төрөөс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх чиглэлд баримтлаж буй бодлого, хорих ял эдлүүлэх, хоригдолд хяналт тавих харилцааг зохицуулж байгаа эрх зүйн эх сурвалжийн зарим хэм хэмжээ, хорих ял эдлүүлэх байгууллагын ангилал², мөн гарч болзошгүй эрсдлийн талаар товч авч үзье.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208 дугаар зүйлийн 208.3-т “Анх удаа ял эдэлж байгаа хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдсэн

хоригдлоос, засарч хүмүүжиж байгаа хоригдлыг засарч, хүмүүжихгүй байгаа хоригдлоос, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн болон зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнд тооцогдож ял шийтгүүлсэн хоригдлыг тусад нь ял эдлүүлнэ”³ гэж хуульчилсан.

Гэвч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн хоригдлыг тусад нь ялгамжтайгаар ял эдлүүлэх барилга байгууламж, техник, хүний нөөцийн боломж хязгаарлагдмал байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх өнөөгийн байдал, чиг хандлага:

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх эрх зүйн орчин тасралтгүй хөгжиж байгаа нь нийгмийн хандлага, шинжлэх ухааны ойлголт, төрийн бодлого, түүнчлэн эрүүгийн ялын бодогод өөрчлөлт орж байгааг харуулж байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг тойрсон олон улсын хууль, эрх зүйн орчин байнга хувьсан өөрчлөгдөж байдаг бөгөөд, ирээдүйн чиг хандлага, алс хараа, хүрэх үр дүнг тодорхойлсноор учрах эрсдэл, хор уршгийг багасгаж чадна. Олон улсад эрүүгийн эрх зүй, ял шийтгэлийн бодлогод өөрчлөлт орж

¹ United Nations Office on Drugs and Crime. <World Drug Report 2016-web.pdf>. New York 2016

²Тухайлбал: Нийт хорих анги нь дэглэмийн хувьд: нээлттэй, хаалттай, байршлын хувьд нийслэл буюу Улаанбаатар хотын бүсэд 10

хорих анги, аймгийн төвд 7, хот, суурингийн гадна 8 хорих анги үйл ажиллагаагаа явуулж байна.

³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. Уб хот., 2017 он. №24

буй дараах хандлагууд өсөн нэмэгдэж байна.

Хор хөнөөлийг бууруулах-Harm reduction: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хэтрүүлэн хэрэглэхээс урьдчилан сэргийлэх санаачилга, нийгмийн эрүүл мэндийн асуудал болох донтолтыг арилгах эмчилгээний сонголтууд нэмэгдүүлэх

Каннабисыг хууль ёсны болгох-Cannabis legalization: АНУ-ын муж улсын хэмжээнд амралт зугаалгын каннабисыг хууль ёсны болгохыг нэмэгдүүлж, холбооны цагийн хуваарь болон болзошгүй хууль ёсны талаар маргаан өрнүүлж байна.

Гэмт хэрэгт тооцохгүй байх-Decriminalization: Эмчилгээний зориулалтаар тодорхой хэмжээний мансууруулах бодис хэрэглэснийг гэмт хэрэгт тооцохгүй байх,

Сэтгэцийн тусламжтай эмчилгээ-Psychedelic-assisted therapies: PTSD болон сэтгэл гутрал зэрэг өвчнийг эмчлэхэд зориулагдсан MDMA ба псилоцибин зэрэг бодисуудын эмчилгээний чадавхийг нэмэгдүүлэх зэрэг.

Сүүлийн жилүүдэд олон улсад мэдэгдэхүйц ахиц дэвшил гарсан хэдий ч хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой хууль, эрх зүйн орчин нарийн төвөгтэй хэвээр байгаа бөгөөд үүнд байнгын үнэлгээ, тандан судалгаа шаардлагатай.

Хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх стратеги нь түүний хор хөнөөлийг бууруулах, эмчилгээний хэрэглээг судлах, хэрэглээ, донтолтой тэмцэхэд нотолгоонд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх явдлаар тодорхойлогдож байна. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт

бодисыг тойрсон хууль, эрх зүйн орчин өөрчлөгдөж байгаагийн зэрэгцээ нийгмийн эрүүл мэнд, хор хөнөөлийг бууруулах, нөхөн сэргээх, эмчлэхэд чиглэсэн олон талт стратеги руу аажмаар шилжиж байна.

Хамгийн чухал чиг хандлагын нэг бол хор хөнөөлийг бууруулахад ихээхэн анхаарал хандуулж байгаа бөгөөд хууль сахиулах байгууллагууд зөвхөн эрүүгийн эрх зүйн хөндлөнгийн оролцоонд найдах хязгаарлалтыг улам бүр хүлээн зөвшөөрч байна. Зүү солилцох хөтөлбөр, тунг хэтрүүлэн хэрэглэхэд бэлэн байгаа эмүүд (налоксон гэх мэт), донтолтоос ангижрах эмчилгээний хүртээмжийг сайжруулах нь энэ аргын чухал тал юм.

Сүүлийн жилүүдэд гарч буй гол чиг хандлага бол зарим эм, тэр дундаа каннабисыг эмнэл зүй, анагаах, зугаа цэнгэлийн зориулалтаар хэрэглэхийг хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрч, гэмт хэрэгт тооцохгүй байх, эрүүгийн гэмт хэргээс хасах хандлага гарч байна. Энэхүү шилжилт нь тодорхой бодисуудын эмчилгээний үр өгөөжийн өсөн нэмэгдэж буй шинжлэх ухааны нотолгоо, хар тамхины хэрэглээг шийтгэх арга хэмжээ авахаас илүүтэйгээр хор хөнөөлийг бууруулах, нийгмийн эрүүл мэндийн санаачлагаар шийдвэрлэх хүсэл эрмэлзэлтэй холбоотой юм.

Дээрхээс дүгнэн үзэхэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх хууль, эрх зүйн орчин нь динамик шинжтэй олон талт үзэгдэл бөгөөд хор хөнөөлийг бууруулах, нотлох баримтад суурилсан оролцоо, эрүүгийн эрх

зүйн шинэчлэлд шилжиж байгааг харуулж байна.

Бодлого боловсруулагчид эдгээр ээдрээтэй асуудлуудыг шийдвэрлэх явцад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ болон сэтгэцийн эмгэгээс үүдэлтэй сорилтуудыг үр дүнтэй шийдвэрлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагаа, нийгмийн эрүүл мэнд, хүний эрхийн зарчмуудыг эрэмбэлсэн цогц арга барил чухал юм.

Дүгнэлт, санал

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх, хууль ёсны эргэлтэд хяналт тавих, урьдчилсан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах үйл ажиллагааны гол үндэс нь шинжлэх ухааны судалгаа, түүний үр дүнд суурилсан мэдлэг, мэргэжлийн байгууллага, олон нийтийн оролцоо, дэмжлэгт тулгуурласан хууль, эрх зүйн орчноор тодорхойлогдож байна.

Нийгмийн сөрөг үзэгдэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах асуудал нь бүс нутаг, улс орны үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй бөгөөд олон улсын хамтын ажиллагаа, түншлэл, хууль, эрх зүйн орчин чухал болно.

Бид цаашид хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх эрх зүйн орчин шинэчлэгдэж буй үйл явцыг анхааралтай ажиглаж, нийгмийн эрүүл мэнд, хохирлыг бууруулахад тэргүүлэх ач холбогдол өгөх, зарим эм, ургамал, сэтгэцэд нөлөөт бодисын эмчилгээний чадавхийг судлах, донтолттой тэмцэхэд нотолгоонд суурилсан арга барилыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Иймд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой

гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаатай холбоотой дараах зохицуулалт, практикийг бий болгохыг санал болгож байна. Энэ нь:

1. Шинэ сэтгэцэд нөлөөт бодис (NPS) болон синтетик мансууруулах бодис олширч байгаа нь дэлхийн хэмжээнд хууль, эрх зүйн орчинд сорилт болж байна. Иймд улс орны засгийн газрууд байнга хувьсан өөрчлөгдөж байдаг эдгээр бодисын хэрэглээг зохицуулахын тулд тэдгээрийн тархалт, хэрэглээг хянах, хориглох зохицуулалтыг үндэсний хууль тогтоомжинд тусгаж байх;

2. Darknet хууль бус зах зээл болон эмийн борлуулалтын онлайн платформууд нэмэгдэж байгаа нь хууль сахиулах байгууллагуудад шинэ сорилтуудыг бий болгож бөгөөд олон улсын хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, онлайн хар тамхи борлуулагчид болон криптовалютын гүйлгээнд хяналт тавих тогтолцоог бий болгоход чиглэсэн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх;

3. Нийгмийн эрүүл мэнд, хор хөнөөлийг бууруулах, нотолгоонд суурилсан эмчилгээний стратегийг хэрэгжүүлснээр бид хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх илүү тогтвортой, үр дүнтэй цогц арга барил, арга руу шилжих боломжтой.

Эх сурвалжийн жагсаалт

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.

- Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1972 оны Протоколоор нэмэлт, өөрчлөлт оруулсан “Мансууруулах эмийн тухай” 1961 оны конвенц

- НҮБ-ын 1971 оны “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай” конвенц

- НҮБ-ын 1988 оны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт

бодисын хууль бус эргэлтийн эсрэг”
конвенц

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх
тухай хууль, 2017 он.

- Сэжигтэн, яллагдагчийг
баривчлах, цагдан хорих шийдвэрийг
биелүүлэх тухай хууль, 1999 он.

- Эрүүгийн хууль, 2015 он.

- Монгол Улсын Засгийн
газрын 2017 оны 204 дүгээр тогтоол.

- Монгол Улсын Их Хурлын
2020 оны 52 дугаар “Алсын хараа
2050” Монгол Улсын урт хугацааны
хөгжлийн бодлого батлах тухай”
тогтоол

- Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 68 дугаар “Мансууруулах
болон сэтгэцэд нөлөөт эмийг
импортлох, үйлдвэрлэх, хангах
нийлүүлэх журам”

- Эрүүл мэндийн сайдын 2016
оны А/184 дүгээр “Журам шинэчлэн
батлах тухай тушаал”

- “Хар тамхины гэмт явдал:
шалтгаан, нөхцөл, урьдчилан
сэргийлэх арга зам” сэдэвт эрдэм
шинжилгээний хурлын эмхэтгэл.
УБ., 2018.

- Б.Болдбаатар.

“Мансууруулах сэтгэцэд нөлөөлөх
бодисын хууль бус эргэлтийн эсрэг
үйл ажиллагаа”. УБ., 2012.

- М.Ургамал. “Монгол орны
мансууруулах үйлчилгээтэй
ургамлын төрөл зүйл, тархацын
өнөөгийн нөхцөл байдал”. УБ . 2018.

- United Nations Office on Drugs
and Crime. <World Drug Report 2016-
web.pdf>. New York 2016

- The Social Impact of Drug
Abuse. United Nations Office on Drugs
and Crime., 1995.

- Page 3.

- "Early drug discovery and the
rise of pharmaceutical chemistry"
сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл.
<https://analyticalsciencejournals.onlinelibrary.wiley.com/doi/10.1002/dta.301>

- <https://www.statista.com/topics/7786/global-drug-use/#topicOverview>

- <https://www.undp.org/sustainable-development-goals/good-health>

- https://moh.gov.mn/uploads/files/24f44a6faf8321fc6c39f8534624bb_b.pdf

- <https://www.legalinfo.mn/annex/?lawid=1212>